



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.moh.gov.mn

2022. 07. 21 № 2/3360
таний -ны № -т

Г ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ХАРЬЯА ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН
ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВ,
БУСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

Г Төлөвлөгөө хүргүүлэх тухай

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар хүргүүлж байна.

Тус яамны зүгээс Авлигатай тэмцэх газарт Авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг хагас жил, бүтэн жилээр, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн тайланг жилийн эцэст тус тус салбарын хэмжээнд нэгтгэн хүргүүлдэг. Иймд тухайн жилийн 6 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор “Авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан”, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх ажлын тайлан”-г 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтэст хавсралтаар хүргүүлсэн загварын дагуу тогтмол ирүүлж байна уу.

Энэ жил салбарын хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажлыг хийхээр Эрх бүхий албан тушаалтнуудын /ЭБАТ/ уулзалтыг 08 дугаар сарын эхээр зохион байгуулахаар төлөвлөж байна. Иймээс та бүхэн өөрийн эмнэлгийн Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ы үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг хүсье.

Хавсралт...6...хуудастай

ТӨРИЙН НАРИЙН БИЧИЙН
ДАРГА

Ц.Эрдэмбилиг
Ц.ЭРДЭМБИЛЭГ

144225270

БАТЛАВ.
ТӨРИЙН НАРИЙН БИЧРИЙН
ДАРГА

В. Григорий

Ц.ЭРДЭМБИЛЭГ

АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР
АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ
2022 ОН

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт
НЭГ. ШУДАРГА, ХАРИУЦЛАГАТАЙ, ИЛ ТОД НИЙТИЙН АЛБЫГ БЭХЖҮҮЛЭХ ЗАМААР АВЛИГЫН ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УДИРДАХ БОЛОН ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ХААГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХДАА МЭДЛЭГ БОЛОВСРОЛД СУУРИЛСАН МЕРИТ ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР					
1.1.	Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх;	1.1.1. Төрийн үйлчилгээнд хамаарах хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг мэдүүлэхээр заасан удирдах албан тушаалд нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-аар хянуулж хэвших, мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох;	2022		Ашиг сонирхлын зөрчилгүй этгээдийг албан тушаалд томилсон байна.

		1.1.2. Нийтийн албан томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСҮМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод нээлттэй болгох;	2022		Дүгнэлтүүд нээлттэй, ил тод болсон байна. Дүгнэлтүүдийн байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна.
		1.1.3. Төрийн үйлчилгээний байгууллагын хүний нөөцийн жагсаалт, сүл орон тооны мэдээллийг ил тод болгох;	2022		Хүний нөөцийн жагсаалт ил тод, нээлттэй болсон байна.
1.2	Нийтийн албан томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг ТАЗ-өөс баталсан журмын дагуу боловсруулан баталгаажуулж, шинэчлэн батлах	1.2.1. албан тушаалын тодорхойлолтыг ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг ТАЗ-өөс баталсан журмын дагуу боловсруулан баталгаажуулж, шинэчлэн батлах	2022		Албан тушаалын тодорхойлолт батлагдсан байна.
		1.2.2. албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан, сонгон шалгаруулах журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулж томилох, дэвшүүлэх	2022		Байгууллага чадварлаг хүний нөөцтэй болсон байна.
1.3	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг дагаж мөрдөх	1.3.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангах, холбогдох мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, “Цахим хуудас ажиллуулах, мэдээллийг цахим хуудсанд байрлуулж, түгээх, ашиглах журам”-ыг байгууллагын хэмжээнд баталж, цахим хуудсанд мэдээлэл байрлуулах албан тушаалтны нэрсийг хавсралтаар батлах;			Мэдээллийн ил тод байдал хангагдаж, ил тод байдалд өгөх хөндлөнгийн байгууллагын үнэлгээ сайжирсан байна.

		Захиргааны аливаа шийдвэр гаргахад Авлигын эсрэг хууль, Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг чанд мөрдөх;			
1.4	Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	1.4.1.Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулж, бүх түвшний ажилтнуудыг хамруулах;	2022		Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай мэдээ, мэдээллээр албан хаагчид хангагдсан байна.

ХОЁР. ТӨСӨВ, САНХҮҮ, АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ, ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ, ТӨСВИЙН ХӨРӨНГӨ, ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙГ ҮР АШИГТАЙ, ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛАХ, ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

2.1	Төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл, зарцуулалтын хөндлөнгийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх	2.1.1.Төсвийн зарцуулалтад санхүүгийн хөндлөнгийн хяналт хийх	2022		Эрүүл мэндийн яамтай хамтран ажилласан байна.
2.2	Хандив, тусlamж авахтай холбоотой хязгаарлалтыг мөрдөж, хариуцлагыг нэмэгдүүлэх	2.2.1. “Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллах	2022		Хууль зөрчиж хандив, тусlamж авах асуудал бүрэн зогссон байна.

2.3	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ашиг сонирхлын зөрчлийг тухай бүр мэдэгдэх, тайлбарлах	2.3.1. Албан тушаалтнаас захирагааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдэл, тайлбарыг Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу гаргуулж хэвших	2022		Захирагааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулахад ашиг сонирхлын зөрчил үүсээгүй байна.
-----	--	---	------	--	--

ГУРАВ. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА, ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

3.1	Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах	3.1.1.тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх	2022		Тендер шалгаруулалтын үйл ажиллагаа ил тод болсон байна
		3.1.2.тендер шалгаруулалтын талаар гарсан гомдолыг хянан шийдвэрлэх журмыг шинэчлэх, гаргасан шийдвэр, дүгнэлтийг олон нийтэд ил тод болгох	2022		тендер шалгаруулалтын талаар гарсан гомдолын шийдвэрлэлт ил тод болсон байна
		3.1.3.худалдан авах ажиллагааны бодлого, төлөвлөлтийг сайжруулж, ил тод болгох	2022		Худалдан авах ажиллагаа хууль, журмын дагуу зохион байгуулагдаж, олон нийтэд хардлага үүсгэхгүй болсон байна.
		3.1.4.Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг нээлттэй ил тод мэдээлэх	2022		Худалдан авах ажиллагаа хууль, журмын дагуу зохион байгуулагдаж, олон нийтэд хардлага үүсгэхгүй болсон байна.

		3.1.5. “Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн дагуу тендерийн үнэлгээний хороондд ажиллаж байгаа ажилтнууд мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргах	2022		Тендер шалгаруулалт хуулийн дагуу, ашиг сонирхлын зөрчилгүй зохион байгуулагдсан байна.
		3.1.6. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг ойгуулах худалдан авах ажиллагааны мэдлэгтэй болгох зорилгоор АЗ гэрчилгээ олгох сургалтад ажилтнуудыг хамруулж, тухай бүр тендерийн хороог шинэчлэн байгуулж байх	2022		Худалдан авах ажиллагаа тус бүрт үнэлгээний хороог шинэчлэн байгуулах

ДӨРӨВ. АВЛИГЫН ЭСРЭГ БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, СОЁН ГЭГЭРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4.1	Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, байгууллагын ажилтнуудыг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах	4.1.1.авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хангаж ажиллах	2022		Хагас жил, жилээр хэрэгжилтийн тайланг гаргаж ЭМЯ-нд хүргүүлсэн байна.
		4.1.2.авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх;	2022		Байгууллагын ажилтнуудын авлигын эсрэг боловсрол дээшилсэн байна.
		4.1.3.авлигын эсрэг сайн туршлагыг олон нийтэд түгээх.	2022		

		4.1.4. зорилтот бүлэгт зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, авлигыг үл тэвчих хандлагыг бий болгоход чиглэсэн сургалтыг үе шаттай зохион байгуулах, цахим сүлжээг ашиглах;	2022		
--	--	--	------	--	--

Хянасан:

ТЗУГ-ын дарга

П.Эрхэмбаяр

ТЗУГ-ХХ-ийн дарга

Д.Мөнхцэцэг

Боловсруулсан:

ТЗУГ-ХХ-ийн мэргэжилтэн

Э.Цэрэнчунт